



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2019.06
2019.06



ГАРЧИГ

Аргачлалын тайлбар	3-4
Хүн ам өрхийн зарим үзүүлэлт.....	5
Орон нутгийн төсвийн орлого, зарлага	5-6
Ажиллагсад, ажилгүйчүүд, ажлын байр	6
Мөнгө, банк.....	7
Үнэ.....	7-8
Аж үйлдвэр.....	8
Хөдөө аж ахуй	9-11
Нийгмийн даатгал, нийгмийн халамж.....	11-12
Эрүүл мэнд.....	12-13
Гэмт хэрэг.....	13-14

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:** Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.
- **Эрүүл мэнд, Гэмт хэрэг:** Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
 - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
 - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Гэмт хэрэг:** Аймгийн цагдаагийн газраас захиргааны статистик мэдээгээр нэгтгэн гаргадаг.
- **Эрүүгийн хуульд** эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

 - Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.
 - Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.
 - Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдыг эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.
 - Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.
 - Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.
 - 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.
- **Хэрэглээний үнийн индекс / ХҮИ / гэдэг нь** хэрэглэгчдийн худалдаж авсан бараа үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн

өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

- Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- **Мөнгө, банк:** Монгол банк арилжааны банкуудаас мэдээг авч нэгтгэн, банкуудын үндсэн материалын хамт ирүүлдэг.
- **Төрийн санхүү:** Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймаг, сумын төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймаг, сумын төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- **Хөдөө аж ахуй:** Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар өрхөөс цуглуулж, сумын тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.
- **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.

Нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо: гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2010 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.



ХҮН АМ, ӨРХИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

2018 онд аймгийн хүн ам 88359 болж өмнөх оноос 1.3 хувиар буюу 1116 хүнээр нэмэгдсэн байна. Нийт хүн амыг хүйсээр нь авч үзвэл 50.7 хувь буюу 44829 нь эмэгтэйчүүд, 49,3 хувь буюу 43530 эрэгтэйчүүд эзэлж байна. Байршилаар авч үзвэл 33.8 хувь нь аймгийн төв, 11.9 хувь нь сумын төв, 52.6 хувь нь хөдөө, 1.6 хувь тосгонд байна.

2018 онд Баянхонгор аймаг 26643 өрхтэй болж өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар өсчээ. Нийт өрхийг байршлаар нь авч үзвэл 34.4 хувь нь аймгийн төвд, 12.1 хувь нь сумын төвд, 52.0 хувь нь хөдөөд, 1.5 хувь нь тосгонд байна.

Өрхийн тоо

Сум/Дүүрэг	Өрх - Бүгд	Үүнээс			
		Нийслэл, аймгийн төвд	Хот, тосгонд	Сумын төвд	Хөдөөд
Баацагаан сум	1067	0	0	111	956
Баянбулаг сум	495	0	0	90	405
Баянговь сум	866	0	0	162	704
Баянлиг сум	1072	0	0	292	780
Баян-Овоо сум	877	0	0	207	670
Баян-Өндөр сум	753	0	0	155	598
Баянхонгор сум	9679	9278	78	0	323
Баянцагаан сум	1026	0	0	166	860
Богд сум	908	0	0	189	719
Бөмбөгөр сум	997	0	0	231	766
Бууцагаан сум	1085	0	0	164	921
Галуут сум	1264	0	0	199	1065
Гурванбулаг сум	636	0	0	76	560
Жаргалант сум	939	0	0	196	743
Жинст сум	647	0	0	135	512
Заг сум	634	0	0	189	445
Өлзийт сум	1144	0	0	204	940
Хүрээмарал сум	519	0	0	82	437
Шинэжинст сум	754	0	0	99	655
Эрдэнэцогт сум	1281	0	0	280	1001
НИЙТ	26643	9278	78	3227	14060

Сум/Дүүрэг	БҮХ ХҮН АМ			Сумын төвд			Хөдөөд		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
	1	2	3	10	11	12	13	14	15
Баацагаан	3307	1679	1628	341	165	176	2966	1514	1452
Баянбулаг	1767	877	890	316	157	159	1451	720	731
Баянговь	2922	1420	1502	527	244	283	2395	1176	1219
Баянлиг	3848	1906	1942	975	499	476	2873	1407	1466
Баян-Овоо	2650	1384	1266	574	285	289	2076	1099	977
Баян-Өндөр	2668	1350	1318	529	267	262	2139	1083	1056
Баянхонгор	31685	15127	16558	30271	14424	15847	1139	566	573
Баянцагаан	3590	1811	1779	587	270	317	3003	1541	1462
Богд сум	3113	1516	1597	606	280	326	2507	1236	1271
Бөмбөгөр	3288	1644	1644	786	367	419	2502	1277	1225
Бууцагаан	3670	1836	1834	541	251	290	3129	1585	1544
Галуут сум	4103	2122	1981	648	323	325	3455	1799	1656
Гурванбулаг	2216	1096	1120	246	123	123	1970	973	997
Жаргалант	2961	1474	1487	600	282	318	2361	1192	1169
Жинст сум	2192	1084	1108	432	216	216	1760	868	892
Заг сум	2073	1050	1023	601	313	288	1472	737	735
Өлзийт сум	3870	1945	1925	706	337	369	3164	1608	1556
Хүрээмарал	1748	883	865	239	123	116	1509	760	749
Шинэжинст	2449	1205	1244	291	130	161	2158	1075	1083
Эрдэнэцогт	4239	2121	2118	894	448	446	3345	1673	1672
НИЙТ	88359	43530	44829	10439	5080	5359	47374	23889	23485



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

2019 оны 06 дугаар сарын байдлаар аймгийн төсвийн орлогын дүн 6855.9 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 251.1 сая төгрөгөөр буюу 3.6 хувиар өссөн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг төрөл дээр нь авч үзвэл: ҮХЭХ-ийн татвар 23.8 сая төгрөг, газрын төлбөр 16.5 сая төгрөг, Улсын тэмдэгтийн хураамж 13.7 сая төгрөг, АТӨЯХ-н татвар 24.2 сая төгрөг, ус ашигласны төлбөр 26.8 сая төгрөг, хог хаягдлын хураамж 66.6 сая төгрөгөөр тус тус тасарч, ЦХТА орлого /суутган-1/ 166.9 сая төгрөг, НӨАТатвар 207.4 сая төгрөг, ИОТТХ 8.5 сая төгрөг, ААНБ-ын орлогын албан татвар 85.9 сая төгрөгөөр тус тус давуулан биелэлээ.

Нийт орлогод ААНБ-н орлогын албан татвар 4.1 хувь, нэмүү өртгийн албан татвар 8.2 хувь, ЦХТА орлого 36.9 хувь, авто тээвэр өөрөө авагч хэрэгслийн татвар 5.9 хувь, хүү торгууль 6.5 хувь бусад төлбөр хураамж 14.3 хувийг тус тус эзэлж байна



МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Монгол Банкны аймаг дахь салбараас ирүүлсэн мэдээгээр 2019 оны 7 дугаар сарын 05-ны байдлаар арилжааны банкуудаар 182373.9 сая төгрөг эргэлдэж байна.

Оны эхний 6 сарын байдлаар нийт зээлийн өрийн үлдэгдэл 181204.3 сая төгрөг байгаагийн 178433.6 сая төгрөг нь хэвийн зээл, 2108.8 сая төгрөг нь анхаарал хандуулах зээл /хугацаа хэтэрсэн/, 1831.5 сая нь чанаргүй зээл байна.

2019 оны эхний 6 сарын байдлаар иргэдийн хадгаламж 116647.7 сая төгрөг болжээ. Үүний 34722.5 сая төгрөг нь хугацаагүй хадгаламж, 81857.3 сая төгрөг нь хугацаатай хадгаламж байна.

Аймгийн банкны салбарын нийт ашиг өссөн дүнгээр 9363.5 сая төгрөг болжээ.

№	ХӨРӨНГӨ	2019-07-05
1	Мөнгөн хөрөнгө	3,422,620.1
2	Зээлийн өрийн үлдэгдэл / цэвэр/	181,204,293.1
	Хэвийн зээл	178,433,624.2
	Хугацаа хэтэрсэн зээл	2,108,769.2
	Чанаргүй зээл	1,831,534.6
	Хэвийн бус зээл	488,073.6
	Эргэлзээтэй зээл	123,139.1
	Муу зээл	1,220,321.9
	/ЗТУБАХСАН/	2,191,255.0
	Нийт зээл	182,373,928.0
3	Бусад хөрөнгө	2,634,531.9
4	Үндсэн хөрөнгө / цэвэр /	3,461,566.3
5	Харилцах данс	26,965,372.7
6	Хадгаламж	116,647,757.5
	Хугацаагүй хадгаламж	34,722,547.4
	Хугацаатай хадгаламж	81,857,330.1
	Бусад хадгаламж, сертификат	67,880.0
7	Бусад өр төлбөр	35,511,419.4
8	Ашиг/Алдагдал	9,363,548.5



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Аймгийн өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс 06 сарын байдлаар өмнөх сартай харьцуулсанаар 0.1 хувиар өсчээ, ийнхүү өсөхөд голлож мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүний барааны бүлгийн үнэ өссөн нь нөлөөлжээ.

Харин өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 6.4 хувиар өссөн нь хүнсний бараа, согтууруулах бус ундааны барааны бүлгийн үнэ, согтууруулах ундаа, тамхиний бүлгийн барааний үнэ, тээврийн бүлгийн барааны үнэ өссөнтэй холбоотойгоор өссөн нь харагдаж байна.

Тайлант 07 дугаар сарыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ерөнхий индекс 6.6 хувиар өссөн байгаа нь голлож хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн барааны үнэ, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн барааны үнэ, боловсролын үйлчилгээний бүлгийн барааны үнэ, тээврийн үйлчилгээний бүлгийн барааны үнэ өссөнтэй шууд холбоотой байна.

ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

	<u>2019.06</u>	<u>2019.06</u>	<u>2019.06</u>
	2018.06	2018.12	2019.05
ЕРӨНХИЙ ИНДЕКС	106.6	106.4	100.1
ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	111.9	117.5	99.5
СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	104.9	103.2	100.7
СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	102.8	102.8	100.4
ТАМХИ	102.3	102.3	100.0
ХУВЦАС, БЭС БАРАА, ГУТАЛ	103.9	103.9	100.5
ГУТАЛ	103.7	103.4	100.2
ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД	105.4	102.0	100.0
ОРОН СУУЦНЫ ТЕХНИКИЙН БОЛОН ЗАСВАРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.9	101.0	100.1
УСАН ХАНГАМЖ БОЛОН ОРОН СУУЦНЫ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0	100.0
ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	109.6	103.1	100.0
ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	104.0	102.2	99.9
ГЭР АХУЙН ТАВИЛГА, ХЭРЭГСЭЛ, ХИВС БОЛОН ШАЛНЫ БУСАД ДЭВСГЭР	108.3	105.7	99.5
ГЭР АХУЙН ОЁМОЛ, НЭХМЭЛ ЭДЛЭЛ	91.5	100.0	100.0
ГЭР АХУЙН ЦАХИЛГААН БАРАА	96.7	100.8	99.7
ГЭР АХУЙН ШИЛЭН ЭДЛЭЛ, САВ СУУЛГА	104.1	101.1	100.0
ГЭР АХУЙ, ЦЭЦЭРЛЭГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ХӨДӨЛМӨРИЙН БАГАЖ ХЭРЭГСЭЛ	126.8	102.3	100.7
ГЭР АХУЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БОЛОН БУСАД ЖИЖИГ БАРАА, ГЭРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	102.7	100.4	100.3
ЭМ ТАРИА ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	102.6	103.2	101.8
ЭМ ТАРИА ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ	101.2	104.2	102.4
АМБУЛТОРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	126.6	100.0	100.0
ЭМНЭЛЭГТ ХЭВТЭЖ ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭ	99.4	100.0	100.0
ТЭЭВЭР	106.6	99.9	99.9
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ	99.7	101.4	100.0
ХУВИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ	111.9	98.6	99.7
ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	117.9	100.0	100.0
ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	102.4	100.4	100.2
АМРАЛТ ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ	97.9	102.1	100.0
ДУУ, ДҮРС, ГЭРЭЛ ЗУРАГ, МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	100.9	100.9	100.0
ЧӨЛӨӨТ ЦАГ СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0	100.0
НОМ СОНИН, БИЧГИЙН ХЭРЭГСЭЛ	94.5	105.3	100.0
БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	107.3	99.9	100.0
ЗОЧИД БУУДАЛ НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	97.4	102.3	100.0
БУСАД БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ	104.1	102.6	101.3
ХУВЬ ХҮНД ХАНДСАН ҮЙЛЧИЛГЭЭ	106.6	103.3	101.6
ХУВЬ ХҮНИЙ ЭД ЗҮЙЛ, ХЭРЭГЛЭЛ	93.2	100.0	100.0
САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0	100.0

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ, хүнсний гол нэр төрлийн барааны үнэ,сараар

				2019.06
				2018.06
1-р зэргийн гурил	1200	1200	1200	100.0
Хонины мах, кг	7300	5500	9500	130.1
Үхрийн цул мах, кг	7000	8000	11000	157.1
Ямааны мах, кг	6500	4800	9000	138.5
Элсэн чихэр, кг	2000	2000	2000	100.0
Цагаан будаа, кг	2200	2200	2200	100.0
Шингэн сүү, л	3000	3000	2500	83.3
Цагаан ноолуур, кг	100000	50000	80000	80.0
Бор ноолуур, кг	93000	50000	80000	86.0
Бензин А-80, л	1680	1905	1890	112.5
Бензин АН-92, л	1810	1935	1950	107.7
Дизел түлш, л	2140	2500	2480	115.9

ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, төг

				2019.06
				2018.06
Тэмээний эр ноос			3500	#DIV/0!
Тэмээний эм ноос			3500	#DIV/0!
Адууны дэл	10000	8000	4000	40.0
Адууны сүүл	10000	8000	5000	50.0
Адууны шир	5000	10000	5000	100.0
Үхрийн шир 1.8-2.3 метрийн хэмжээтэй	10000	15000	5000	50.0
Үхрийн шир 2.3 метрээс дээш хэмжээтэй	0	0	0	#DIV/0!
Хонины ноостой нэхий	4500	1000	1000	22.2
Ямааны ноолууртай арьс	0	38000	0	#DIV/0!

**ХӨДӨӨ АЖ АХУЙ**

Жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 2018 онд манай аймгийн мал сүргийн нийт дүн 4249.5 мянга болж, 2017 оныхоос 7.4 хувь буюу 338.3 мянган толгойгоор буурлаа. Нийт дүнгээр адуун сүргийн тоо 175.9 мянга, үхэр 239.8 мянга, тэмээ 57.4 мянга, хонь 1297.5 мянга, ямаа 2478.9 мянган толгойд болж, 2017 оныхоос адуу -4184, үхэр -565, хонь -83658, ямаа -252897 толгойгоор тус тус буурч, тэмээн сүрэг 3039 толгойгоор өссөн байна. .

Нийт мал сүргийн дотор адуу 4.1 хувь, үхэр 5.6 хувь, тэмээ 1.4 хувь, хонь 30.6 хувь, ямаа 58.3 хувийг тус тус эзэлж, өмнөх оныхоос ямааны эзлэх хувь 1.2 пунктээр буурч, хониных 0.5 пункт, адууных 0.2 пункт, үхэр 0.4 пункт, тэмээнийх 0.2 пунктээр өссөн байна.

Малын тоо Баянбулаг, Галуут, Гурванбулаг, Жаргалант сумдад 874 - 21216 толгойгоор өсч, бусад сумд 3785 - 40258 толгойгоор буурчээ.

Малын тоо 2018 онд

МЯН.ТОЛ

	Малын тоо		2017/2018		Нийт дүнд эзлэх хувь	
	2017	2018	Зөрүү	Хувь	2017	2018
Бүгд	4587.7	4249.5	(338.3)	92.6	100.0	100.0
Адуу	180.1	175.9	(4.2)	97.7	3.9	4.1
Үхэр	240.3	239.8	(0.6)	99.8	5.2	5.6
Тэмээ	54.3	57.4	3.1	105.6	1.2	1.4
Хонь	1381.1	1297.5	(83.7)	93.9	30.1	30.6
Ямаа	2731.8	2478.9	(252.9)	90.7	59.5	58.3

Хамгийн олон мал тоолуулсан эхний 5 сумд Баацагаан (322229), Галуут (289552), Бууцагаан (279027), Бөмбөгөр (270868), Баянцагаан (247016) сумууд орж байна. Малын төрлөөр нь авч үзвэл тэмээгээр Баянлиг 23064, адуугаар Галуут 19857, үхрээр Эрдэнэцогт 51745, хониор Галуут 126616, ямаагаар Баацагаан 241995 толгойг тус тус тоолуулж аймагтаа тэргүүлж байна.

Манай аймаг улсад нийт малын тоогоор 4249.5 зургаад, ямааны тоогоор 2478.9 нэгдүгээрт, тэмээний тоогоор 57.4 хоёрдугаарт, үхрээр 239.8 есдүгээрт, адуугаар 175.9 аравт, хониор 1297.5 арваннэгдүгээрт орж байна.

Аймгийн хэмжээнд 06 дугаар сарын мал төллөлт, төл бойжилтийн мэдээгээр оны эхний хээлтэгчийн 69.3 хувь буюу нийт 1355678 хээлтэгч мал төллөсөн ба гарсан төлийн 98.3 хувь буюу 1332941 төл эсэн мэнд бойжиж байна. Бойжсон төлийг төрлөөр нь харвал ботго 5596, унага 30428, тугал 57629, хурга 480366, ишиг 758922 толгой тус тус бойжсон байна.

2019 оны 6 дугаар сарын том малын зүй бус хорогдлын мэдээгээр нийт 29097 толгой мал хорогдсон нь оны эхний малын 0.7 хувийг эзлэж байна. Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл тэмээ 82, адуу 1579, үхэр 3442, хонь 8537, ямаа 15457 толгой тус тус хорогджээ. Мөн нийт хорогдсон малын 23.5 хувь буюу 6852 толгой хээлтэгч мал хорогдсон байна.



АЖ ҮЙЛДВЭР

2019 оны 06 дугаар сарын байдлаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт 14236.6 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 8794.8 сая төгрөгөөр буюу 2.5 дахин өссөн байна, ингэж өсөхөд нөлөөлсөн гол шалтгаан нь алт олборлолт, борлуулалт өссөнтэй холбоотой юм

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт өссөн дүнгээр /мян.төг/

	Зургаадугаар сар		
	2018	2019	2019.06 / 2018.06
	5441761	14236610	261.6

Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт
/өссөн дүнгээр/

		Наймдугаар сар		
Алт	Кг	13,7	107,4	783,9
Нүүрс	Мян.тн	33.3	12	36
Нарийн боов	тн	67.415	76.9	114.2
Талх	тн	77.48	84.5	109.1
Хиам	тн	4	4,8	120
Дулаан	Мян.Гкал	334.8	202.01	60.3
Түгээсэн цэвэр ус	Мян.м3	301	302,9	100.5
Боловсруулсан шингэн сүү	Мян.л	1.8	3,158	175,4



НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ

2019 оны эхний 6 сард тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэрт 16368.1 сая төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт 3750.8 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 1031.5 сая төгрөг, цэргийн тэтгэвэрт 482.7 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжид 30.8 сая төгрөг, жирэмсэн болон амаржсаны тэтгэмжид 612.3 сая төгрөг, оршуулгын тэтгэмжид 194.0 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэрт 40.0 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 11.2 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжид 189.9 сая төгрөг тус тус олгожээ

Нийгмийн халамжийн сангаас 2019 оны 06 дугаар сард 5217 хүнд 2974.7 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, жирэмсэн эхийн тэтгэмж 1804 эхэд 218.6 сая төгрөг, алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж 7504 эхэд 998.9 сая төгрөг, алдар цолтой 23 ахмадад 22.6 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн бол Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа нэг удаагийн хөнгөлөлт, тусламж 3482 хүнд 521.5 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж 233 хүнд 57.2 сая төгрөг тус тус зарцуулсан байна.



АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР, АЖИЛЛАГСАД

2019 оны эхний 6 сарын байдлаар аймгийн бүртгэлтэй ажилгүй иргэд 1111 болж өмнөх оны мөн үеэс 21.5 хувиар өсчээ. Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 57.8 хувь буюу 642 эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 15-44 насныхан 77.5 хувь буюу 861 иргэн, 45 дээш насныхан 250 иргэн 22.5 хувийг эзлэж байна. Харин боловсролын түвшнээр харвал бүрэн дунд хүртэл боловсролтой иргэд 60.8 хувь,

тусгай мэргэжлийн болон техникийн болон дээд, боловсролтой иргэд 38.3 хувь, магистр, докторын боловсролтой иргэд 0.8 хувийг тус тус эзлэж байна.

Эхний 6 сарын байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүдээс 440 иргэн үүнээс 216 эмэгтэй ажилд зуучлагдан оржээ. Ажилд орсон иргэдийн 73.2 хувь буюу 322 нь 15-44 насныхан байна.

Шинэ ажлын байранд нийт 247 иргэн ажиллаж байгаа бөгөөд үүний 56.7 хувь буюу 140 эмэгтэйчүүд байна. Шинэ ажлын байранд ажиллаж байгаа иргэдийг эдийн засгийн салбараар харвал Хөдөө аж ахуйн салбарт 12, Боловсруулах үйлдвэрийн салбарт 83, Худалдааны салбарт 30, мэдээлэл холбоо 6, төрийн удирдлага болон албан журмын нийгмийн хамгаалалд 20, боловсролд 48, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 19, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа 13, бусад салбаруудад 2-3 хүнд шинэ ажлын байр гаргаж ажиллаж байна.

Эхний 6 сарын байдлаар нийт 669 ажлын байрны захиалга ирсэн байна. Ажлын байрны захиалгыг эдийн засгийн салбараар үзвэл Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгаалалд 15, Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 9, Хөдөө аж ахуйн салбарт 76, Барилгын салбарт 74, Боловсролын салбарт 51, Үйлчилгээний салбарт 111, уул уурхай олборлолтын салбарт 111, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн салбарт 29, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 90, бусад салбаруудад 1-4 ажлын байрны захиалга иржээ.



ЭРҮҮЛ МЭНД

2019 оны 6 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд 1041 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 28 төрөлтөөр өссөн байна. Нийт төрсөн эхийн 90.1 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, сум дундын, сумын эмнэлэгт 9.9 хувь нь төржээ. Нялхасын эндэгдэл эхний 6 сарын байдлаар 14 гарчээ.

Аймгийн хэмжээнд 6 сарын байдлаар нийт 854 халдварт өвчин бүртгэгдэж 10000 хүн амд 97.3 байгааг 2018 онтой (80.1) харьцуулахад 17.2 хувиар нэмэгдэж, сүрьеэгийн 1 нас баралт бүртгэгдсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад БЗДХ-ын тохиолдлын тоо нэмэгдэж, нийт халдварт өвчний 84.1 хувийг эзэлж байна. Бүртгэгдсэн БЗДХ-ын 718 тохиолдлын 42.5 хувийг заг хүйтэн, 43.3 хувийг трихомониаз, 14.2 хувийг тэмбүүгийн өвчлөл эзэлж байгаа нь анхаарал татаж байна.


Тайлант оны эхний 6 сарын байдлаар нас баралтын 242 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 35 тохиолдлоор буурч, нийт нас баралтын 27.7 хувь нь эмнэлэгт нас барснаас 31.3 хувь нь хоног болоогүй нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй байна.(2018 онд 28.3 хувь) Эхний 6 сарын байдлаар хорт хавдрын 44 нас баралт, осол гэмтлийн 34 нас баралт бүртгэгдсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад буурсан дүнтэй байна.

Нийт 8794 түргэн тусламжийн дуудлага бүртгэгдсэний 18.7 хувийг алсын, 5.2 хувийг осол гэмтлийн дуудлага эзлэж байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад түргэн тусламжийн дуудлага, нийт дуудлагад эзлэх алсын болон осол гэмтлийн дуудлага буурсан байна.



ГЭМТ ХЭРЭГ

Тухайн сард нийт 2123 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгав. Үүнээс:



Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 93,1%-ийг 5 хоногт, 6,8%-ийг 6 ба түүнээс дээш хоногт, Зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 1209 буюу 97%-ийг 3 хоногт, 36 буюу 2,9%-ийг 4 ба түүнээс дээш хоногт тус тус шалгаж шийдвэрлэсэн.

1. Бүртгэгдсэн гэмт хэрэг:


2019 оны 06 дугаар сард орон нутгийн хэмжээнд **5060** гэмт хэрэг бүртгэгдсэний **286** буюу **5.6** хувь нь Баянхонгор аймагт бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үедтэй харьцуулахад 55 нэгжээр буюу 23.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. **Бүртгэгдсэн хэргийн илрүүлэлт:**

/хувиар/


Бүртгэгдсэн гэмт хэрэг

	2018 оны 05 сар	2019 оны 05 сар	Өсөлт, бууралт		2018 оны 05 сар	2019 оны 05 сар	Өсөлт, бууралт /нэгжээр/	
			тоогоор	Ху				
Бүртгэгдсэн нийт хэрэг	17980	15800	2180	-12				
Орон нутагт бүртгэгдсэн гэмт хэрэг	4597	5060	463	1	Улсын хэмжээнд	22.5%	29.3%	6.8 нэгжээр өссөн
Баянхонгор аймаг гэмт хэрэг	231	286	55	23	Орон нутагт	14.4%	19.6%	5.2 нэгжээр өссөн
					Баянхонгор аймагт	35.7%	52.5%	16.8 нэгжээр өссөн

Баянхонгор сумын багуудад гарсан гэмт хэрэг



Гэмт хэргийн гаралтыг сумдаар нь харьцуулсан байдал



2019 оны 06 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/

Хэргийн ангилал	2018 оны 06 сар	2019 оны 06 сар	Харьцуулалт
Хүнийг санаатай алах	1	2	2 100%
Золгүй учрал	4	5	1 25%
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	86	89	3 3.4%
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	9	24	15 2.3 дахин
Өмчийн хулгай	121	147	26 21.4%
Тээврийн хэрэгслийн хулгай	9	2	-7 -77.7%
Мал хулгайлах	21	44	23 1.3 дахин
Дээрэм	2	1	-1 -100%
Залилах	13	14	1 7.6%
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	1	1	- Ижил түвшинд
ХАБЭГХ	4	8	4 100%

Бусад	28	27	-1	-3.6%
-------	----	----	----	-------

Урьд оны мөн үетэй харьцуулсан үзүүлэлтийг хувиар илэрхийлэн үзвэл:

+Хүнийг санаатай алах 100%-иар, Хүний амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 25%-иар, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 19%-иар, Хөдөлгөөний аюулгүй байдал эсрэг гэмт хэрэг 100%-иар, Мал хулгайлах гэмт хэрэг 1.3 дахин, Хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2.3 дахин, тус тус өссөн байна.

-Тээврийн хэрэгслийн 77.7 хувиар, Дээрэм 100 хувиар тус тус буурсан.

=Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг ижил түвшинд байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал

Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал	2018 оны 05 сар	2019 оны 05 сар	Нэгжээр	Өсөлт бууралт /хувиар/
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	10	7	-3	-30%
Эмэгтэй хүн оролцсон	19	14	-5	-36.3%
Хүүхэд оролцсон	10	3	-7	-70%
Бүлэглэн гүйцэтгэсэн	26	41	15	57.6%
Согтуугаар	34	50	16	47%


Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн газар

Баянхонгор аймагт бүртгэгдсэн 286 гэмт хэргийн 103 буюу 36% нь гэр оронд, 42 буюу 14.6% нь гудамж талбайд, 25 буюу 8.7% нь олон нийтийн газар, 18 буюу 6.2% нь төрийн байгууллагад, 1 буюу 0.4% нь аж ахуй нэгж байгууллагад, 4 буюу 1.6% нь авто замд, 82 буюу 33.7% нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Үйлдэгдсэн гараг:

Үйлдэгдсэн цаг:

Даваа	• 35
Мягмар	• 43
Лхагва	• 41
Пүрэв	• 51
Баасан	• 44
Бямба	• 31
Ням	• 41



Гэмт хэрэгт холбогдсон хүн:

Энэ хугацаанд нийт 205 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 99 нэгжээр буюу 93.3 хувиар өссөн бөгөөд 9 эмэгтэй, 3 хүүхэд, 193 эрэгтэй хүн холбогдон шалгагдсан байна.

3.1. Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, байгууллага:

Гэмт хэргийн улмаас 287 иргэн хохирч, үүнээс 90 хүн гэмтэж, 7 хүн нас барсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал гэмтсэн хүн 8 нэгжээр буюу 9.7%-иар, нас барсан хүн 3 нэгжээр буюу 75 хувиар өссөн байна.

Гэмт хэргийн улмаас 587.7 сая төгрөгийн хохирол учирснаас 153 сая төгрөгийг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт өнгөрсөн оны мөн үеэс 1.4 дахин өссөн үзүүлэлттэй байна.

2. Зөрчлийн мэдээ

Баянхонгор аймгийн хэмжээнд 2019 оны 06 дүгээр сарын байдлаар 11201 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5453 нэгжээр буюу 94.9% өссөн үзүүлэлттэй байна. Зөрчлийг ердийн журмаар /бэлэн бус торгуулийн арга хэмжээгээр/ 10369 зөрчлийг 174246.9 мянган төгрөгөөр, 590 зөрчлийг хялбаршуулан шалгах журмаар шийдвэрлэж 143690.0 мянган төгрөгөөр, нийт 10959 зөрчлийг 317936.9 мянган төгрөгөөр торгосон.

-133 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 15 нэгжээр буюу 10.1%-иар өссөн үзүүлэлттэй байна.

-232 зөрчлийг торгож, эрх хассан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 6 нэгжээр буюу 2.7 хувиар өссөн байна.



**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**